

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.040.20

Байгаль орчныг хамгаалах . Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам.	MNS 17.2.3.16 - 88 MNS 17.2.3.01 - 80-ын оронд
Охрана природы. Атмосфера. Правила контроля качества воздуха населенных пунктов	ГОСТ 17.2.3.08-86

Улсын стандартын газрын даргын 1988 оны 248 дугаар тушаалын дагуу 1989 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

**Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрдөнө.**

Энэ стандарт одоо байгаа болон шинээр байгуулах хот суурин газрын агаарын чанарыг хянах журмыг тогтооно.

Стандарт нь үйлдвэрийн газрын нутаг дэвсгэрийн орчны агаарын чанарыг хянах журамд хамаарахгүй. Энэ стандарт ЭЗХТЗ-ийн 1925-79 стандартын сорьц авах тоо, үргэлжлэх хугацаа ба аргын хэсэгтэй тохирно.

### 1 ХЯНАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**1.1** Агаарын бохирдлыг хянах харуулыг суурин, маршрутын, нүүдлийн (бамбар утааны доорх) гэж 3 ангилна.

**1.2** Суурин харуул агаар бохирдуулагч бодисны агуулгыг тасралтгүй хэмжих бүртгэх эсвэл агаарын сорьцыг шинжилгээнд зориулан тогтмол авах ажлыг гүйцэтгэнэ.

Хэд хэдэн суурин харуултай хотод агаар бохирдуулах үндсэн болон түгээмэл тархсан бодисын агуулгын удаан хугацааны өөрчлөлтийг хянах, илрүүлэх зорилгоор тэдгээрээр 1-2-ыг нь тулгуур болгон ажиллуулна.

**1.3** Маршрутын харуул сонгож тогтоосон цэгүүдэд нүүдлийн багаж төхөөрөмжөөр ажиглалт явуулж, агаарын сорьцыг тогтмол авах ажлыг гүйцэтгэнэ.

**1.4** Нүүдлийн (бамбар утааны доорх) харуул бохирдлын тухайн эх үүсвэрийн нөлөөллийн бүсийг тогтоох зорилгоор бамбар утаа (хий) -ны доор агаарын сорьц авах ажлыг гүйцэтгэнэ.

### 2 Харуулын тоо, байршил

**2.1** Агаарын бохирдлыг хянах харуул бүрийг үл тоосрох гадаргуутай хатуу хөрс, цардмал талбай, зүлгэн дээр зүг бүрээс нь салхилах боломжтой задгай газар, өөрөөр хэлбэл ажиглалт, хэмжилтэнд нөлөөлөх барилга, ногоон зурвас зэрэг зүйлс ойр орчимд нь байхгүй газар байрлуулбал зохино.

**2.2** Суурин болон маршрутын харуул байрлуулах газрыг сонгож авахдаа хотын агаарт бохирдуулагч бодисын тархах нөхцөл болон үйлдвэр, авто тээвэр, ахуйн зэрэг бусад эс үүсвэрийн хаягдлаар хэрхэн бохирдож байгаа байдалд хийсэн урьдчилсан судалгааны үндсэн дээр тогтооно.

### **MNS 17.2.3.16 - 88**

Тэдгээр харуул нь хот суурин газрын төв хэсэг, орон сууцны хороолол, амралтын бүс, тээврийн хөдөлгөөний нягтралтай газруудад байрлавал зохино.

**2.3** Суурин харуулын байршлыг сонгохдоо орон нутгийн Байгаль орчныг хамгаалах газар, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын станцтай урьдчилан зөвшөөрөлцсөн байвал зохино.

Тулгуур суурин харуулыг шилжүүлэн байрлуулах ажлыг Байгаль, орчныг хамгаалах яамны зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

**2.4** Бамбар утааны доор сорьц авах цэгийг агаарт бохирдуулагч бодис тархах зүй тогтлыг тооцсоны үндсэн дээр тухайн эх үүсвэрээс янз бүрийн зайд сонгож авна.

**2.5** Харуулын тоо, тэдгээрийн байршлыг оршин суугчдын тоо, хот суурин газрын талбайн хэмжээ, газар нутгийн хотгор гүдгэрийн байдал, үйлдвэрийн районы байршил, хөгжлийн хэтийн төлөв, амралт, рашаан сувиллын бүсийн байрлалт, тээврийн хөдөлгөөн гол замуудын сүлжээ, түүний хотын дэвсгэр нутгат тархсан байдал зэргийг тооцож үзсэний үндсэн дээр тогтооно.

**2.6** Суурин харуулын тоог хот суурин оршин суугчдын тооноос хамааруулж:

25 мянга хүртэлх хүн амтай хотод нэг харуул,

25-100 мянган хүн амтай хотод 2-3 харуул,

100 мянгаас дээш хүн амтай хотод 50 мянган оршин суугч тутамд нэг харуул ноогдохоор тус тус тогтооно.

**2.7** Хот суурины агаар бохирдуулах эс үүсвэрийн тоо, байршил болон газрын гадаргын хотгор гүдгэрийн байдлыг харгалзан 0,5-5 км<sup>2</sup> тутамд суурин болон маршрутын харуул нэг байхаар тогтооно.

**2.8** Агаарын бохирдлын судалгааг өргөн хүрээтэй явуулах шаардлагатай үед Байгаль орчныг хамгаалах яам, Эрүүлийг хамгаалах яамны зөвшөөрлөөр суурин харуулын тоог олшруулж болно.

## **3 АЖИГЛАЛТЫН ХУГАЦАА, ХӨТӨЛБӨР**

**3.1** Суурин харуулын ажиглалтын хөтөлбөр нь бүрэн, бүрэн бус, хураангуйлсан, хоногийн гэсэн 4 төрөл байна.

**3.2** Бүрэн хөтөлбөрийн ажиглалтыг, бохирдуулагч бодисын хоногийн дундаж болон нэг удаагийн агууламжийг тодорхойлох зорилгоор хийнэ.

Бүрэн хөтөлбөрийн ажиглалтаар агаар бохирдуулагч бодисын агууламжийг өдөр бүр автомат багаж төхөөрөмжөөр тасралтгүй бүртгэх эсвэл ижил хугацааны зайтайгаар хоногт 4-өөс доошгүй удаа (орон нутгийн цагаар 1,7,13,19 цагт) сорьц авах ажлыг гүйцэтгэнэ.

Ажиглалтыг шилжих графикаар Мягмар, Пүрэв, Бямба гаригт хийвэл түүнийг бүрэн хөтөлбөрийн ажиглалт гэж үзнэ.

**3.3** Агаар бохирдуулагч бодисын нэг удаагийн агууламжийн мэдээлэл гаргаж авахаар өдөр бүр орон нутгийн цагаар 7,13,19 цагт ажиглалт явуулахыг бүрэн бус хөтөлбөрийн ажиглалт гэнэ.

**3.4** Өдөр бүр орон нутгийн цагаар 7,13 цаг бохирдуулагч бодисын нэг удаагийн агууламжийн мэдээлэл гаргаж авахаар хийх ажиглалтыг хураангуйлсан хөтөлбөрийн ажиглалт гэнэ.

Хураангуйлсан хөтөлбөрийн ажиглалтыг агаарын температур  $-45^{\circ}\text{C}$ -аас хүйтэн үед болон бохирдуулагч бодисын сарын дундаж агууламж зөвшөөрөх хэмжээнээс 20-иос доошгүй дахин буюу тухайн бодисыг шинжлэх аргын мэдрэх чадварын доод хязгаараас бага байх газар хийнэ.

**3.5** Хоногийн турш тасралтагүй сорьц авах замаар бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламжийн мэдээлэл гарган авах ажиллагааг хоногийн хөтөлбөрт ажиглалт гэнэ.

**3.6** Цаг агаарын тааламжгүй нөхцөлийн болон бохирдуулагч бодисын хэмжээ эрс ихэссэн үед ажиглалтыг 3 цаг тутамд хийнэ. Энэ үед сорьцыг гол эх үүсвэр болон хүн ам нягт суудаг газарт бамбар утаан доороос авч шинжилнэ.

**3.7** Агаарын сорьц авахын хамт цаг уурын дараах элементүүдэд: салхины чиглэл, хурд, агаарын температур, даралт, цаг агаар ба хөрсний гадаргын (гадаргын шинж чанар, чийгшилийн байдал) төлөв байдалд ажиглалт хэмжилт хийнэ.

**3.8** Зарим харуулд ажиглалтын хугацааг нэг цагаар хойшлуулж, ургашлуулж болох ба шаардлагатай үед амралт, ёслолын өдрүүдэд ажиглалт хийж болно.

**3.9** Тулгуур суурин харуулд агаар дахь үндсэн бохирдуулагч бодис: тоос, хүхэрлэг хий  $\text{SO}_2$ , нүүрстөрөгчийн исэл  $\text{CO}$ , азотын давхар исэл  $\text{NO}_2$  болон хот суурин газрын үйлдвэрийн хаягдлын шинж чанарыг тусгасан бусад онцлог бодисын ажиглалт хийнэ.

**3.10** Суурин харуул (тулгуур харуул хамаарахгүй) бохирдуулагч онцлог бодисын ажиглалт хийхийн хамт үндсэн бохирдуулагч бодисын ажиглалтыг хураангуйлсан хөтөлбөрөөр (3,4) хийж болно.

Хэрэв эдгээр үндсэн бохирдуулагч бодисын сарын дундаж агууламж нь хоногийн дундаж зөвшөөрөхүйц агууламжаас 2 дахин бага хэмжээтэй байвал ажиглалт хийхгүй байж болно.

**3.11** Суурин харуул бүрийн ажиглалт хийх бохирдуулагч бодисын жагсаалтыг Байгаль, орчныг хамгаалах яам, Эрүүлийг хамгаалах яамнаас тогтоож өгнө.

**3.12** Маршрутын харуулд тухайн хот суурины үйлдвэрийн хаягдлын шинж чанарыг төлөөлөх үндсэн бохирдуулагч бодисын ажиглалт хийнэ.

**3.13** Нүүдлийн (бамбар утааны доорх) харуулд тухайн үйлдвэрийн хаягдлын шинж чанарыг нөлөөлөх бохирдуулагч онцлог бодисуудын ажиглалт хийнэ.

**3.14** Эдгээр төрлийн ажиглалтаас гадна эрдэм шинжилгээ, бусад ажлын зорилгоор тогтмол ажиглалтын анхдагч хөтөлбөрийг багтаасан завсрын хөтөлбөрөөр ажиглалт хийж болно.

## **4 СОРЬЦ АВАХ**

**4.1** Агаар бохирдуулагч бодисын нэг удаагийн агууламжийг тодорхойлох сорьц авах хугацаа 20-30 минут байна.

**4.2** Бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламжийг тодорхойлох сорьц авах хугацаа бүрэн хөтөлбөрөөр тодорхой цагт авч байгаа бол 20-30 мин, хоногийн турш тасралтгүй авч байгаа бол 24 цаг байна.

## **MNS 17.2.3.16 - 88**

**4.3** Газар орчмын агаарын бохирдлын сорьцыг газрын гадаргуугаас 1,5-3,5 м-ийн өндөрт авна.

**4.4** Бохирдуулагч бодис нэг бүрийн сорьц авах, хадгалах, тээвэрлэх нөхцөл, химийн урвалж бодис, сорьц авахад хэрэглэх багаж төхөөрөмж болон аргачлалд тодорхой шаардлагыг тухайн бохирдуулагч бодисыг тодорхойлох аргын норматив, техникийн баримт бичигт тусгасан байна.

## **5 АГААРЫН БОХИРДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

**5.1** Агаарт агуулагдах бохирдуулагч бодисын хольцынх нь их багаар жил, сар, хоногийн дундаж болон нэг удаагийн (20-30 мин) хэмжээг тодорхойлно.

**5.2** Хоногийн дундаж агууламж гэдэг нь хоногийн туршид автомат багажаар тасралтгүй хэмжсэн тоололт болон хоорондоо ижил хугацааны зайтайгаар хоногт 4-өөс доошгүй удаа авсан сорьц дахь 1 удаагийн агууламжуудын тоон дундаж юм.

**5.3** Бохирдуулагч бодисын сарын дундаж агууламж гэдэг нь тэр сарын нэг удаагийн болон хоногийн дундаж агууламжийн тоон дундаж юм.

**5.4** Бохирдуулагч бодисын жилийн дундаж агууламж гэдэг нь тэр жилийн нэг удаагийн болон хоногийн дундаж агууламжийн тоон дундаж юм.

**5.5** Агаарын бохирдлын түвшинг тогтоосон журмаар батлагдсан нормативын баримт бичгийн дагуу үнэлнэ.

**ТӨГСӨВ**